

ИНЕГ-ЫН УДИРДЛАГУУД БОЛОН ИКАО-ЫН USOAP АУДИТАД
БЭЛТГЭХ ЗОХИЦУУЛАХ ТӨВИЙН ДУНД ХИЙГДСЭН УУЛЗАЛТЫН
ТЭМДЭГЛЭЛ

2009 оны 12 дугаар сарын 29

Оролцсон хүмүүс:

С.Итгэл –ЭЗЗХА-ны Ерөнхий менежер
С.Манлай- ЗХНХМХ-ийн дарга
С.Ерөөлт – НААХЗА-ны ҮГХ-ийн дарга
Ж.Цолмон – НААХЗА-ны ААХХ-ийн дарга
Н.Ганболд - НААХЗА-ны НТЧХ-ийн дарга
Р.Баатархуяг – НХА-ны дарга
С.Отгонбаяр – ТХА-ны дарга
Ю.Золзаяа –НМХА-ны дэд дарга
А.Азбилэг - ЧХОНБ-ын аюулгүй байдал хамгаалалт хариуцсан дэд захирал
Ч.Сарансүх - НААХЗА-ны НСҮАХХ-ийн а/а-ны хяналтын байцаагч
Н.Энхбат - НААХЗА-ны ААХХ-ийн аэродромын байцаагч
А.Булган - НААХЗА-ны НТЧХ-ийн мэргэжилтэн
Ж.Люда – ЧХОНБ-ын аюулгүй байдлын мэргэжилтэн

ИНЕГ-ын ИКАО-ын аудитад бэлтгэх зохицуулах төв:

- ерөнхий координатор -Д.Батчулуун
- гишүүд /П.Пүрэвсүх, Ө.Батсайхан, П.Гантөгс, Д.Хишгээ, Т.Алтанзул/

Ж.Цолмон: Солонгос улсад ANS чиглэлээр туршлага судласан талаарх танилцуулга хийв.

Д.Батчулуун: Шалгалтын явцад анхаарах нийтлэг зөвлөмж өгөв үү?

Ж.Цолмон: Урьдчилан бөглөсөн Протоколын асуулгуудын цаад утгыг олж хариулт тавих ёстой гэж зөвлөсөн. ‘No’ гэсэн хариулт болгоныг анхаар!, ОЗШШ –тай хамаарал бүхий асуултыг анхаарах хэрэгтэй гэсэн.

Д.Батчулуун: Хүмүүстэй уулзах явцад ямар сэтгэгдэл төрөв? Бид энэ шалгалтыг давж чадахаар байна уу?

Ж.Цолмон: Тэдний бүх юм эмх цэгцтэй, төгөлдөржсөн байна. Бүгд хугацаатай, хариуцах эзэнтэй байна. Хэрэв SAAQ дээр ‘No’ гэсэн хариулт байвал аудиторрууд Яагаад? гэж их сонирхдог тул аль болох ‘Yes’ гэж хариулах хэрэгтэй гэсэн. Хэрэв “Yes” гэж хариулбал “Show me” гэдэг тул заавал хэрэгжилтийг хангасан байх шаардлагатай гэж зөвлөсөн.

Ч.Сарансүх: Протоколын асуултуудаар бидний бэлдсэн хавтаснуудыг аудиторруудад ерөөсөө үзүүлж болохгүй гэсэн. Протоколын асуулт бүрээр хариулж, хэрэгжилтийг харуулах хавтас нээсэн байна. Хагас жилийн өмнөөс компанитай уулзаж хамтарч ажиллах хэрэгтэй байна. Зөвхөн өөрсдийн хэрэгцээнд хэрэглэнэ гэсэн. Аудиторруудыг завтай бүү байлга, ямагт завгүй байлга гэж зөвлөсөн.

Д.Батчулуун: НМХА, НХА, Аэромонгол, г.м хаана очихоо ИКАО-гаас ирсэн аудиторрууд өөрсдөө сонгодог.

Н.Ганболд: ИКАО-ын аудитад НТЧ-ийн хэлтсээс хэрхэн бэлдэж байгаа талаар танилцуулга хийв.

Ж.Цолмон: Сургалт, номын сан, албадлагын журам г.м. бүх хэлтэс хамаарах нийтлэг асуудлууд байна. ANS-ийн зөвлөхийг 1 сард болгож наашлуулж өгөөчээ. 3 дугаар сард гэвэл оройтож байна. Солонгосоос н.Park-ыг 1 сард авчирмаар байна. Энэ хүн бол ANS-ийн 5-н чиглэлээр 30–н жил ажиллсан их туршлагатай хүн. Хонг-Конгоос ирэх зөвлөх 3 дугаар сард ирдгээрээ ирнэ биз, бидэнд урьдчилсан аудитыг олон хийлгэвэл сайн байна.

Д.Батчулуун: Бүгдээрээ өөрсдөдөө хамааралтай бичиг баримтын жагсаалтыг гаргамаар байна. Ялангуяа, үйлдвэрлэлийнхэн болон мэргэжлийн хэлтсүүд үүн дээр сайн анхаарч хараарай! Монгол улсад ИКАО-гаас 2001 онд хийсэн аюулгүй ажиллагааны аудитын дутагдлууд одоо бүгд хаагдсан эсэхийг эргэж хараад хэрэв хаагдаагүй асуултууд байвал хаах хэрэгтэй байна. 2007 онд ИКАО-гаас хийсэн аюулгүй байдлын дутагдлууд ч мөн адил үүнд хамаарна. Хаагдаагүй асуултуудаар жагсаалт гаргаад бүгдийг хаах хэрэгтэй байна.

Тэмдэглэл хөтөлсөн: Т.Алтанзул